



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/146/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Ай Жэй Эйч Аудит аудит ХХК-ийн Захирал: Г.Энхмаа Утас: 77450279 99040059 Цахим хаяг: ijahaudit2020@gmail.com</p>
---------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Төлбөрийн акт	8
5.2 Албан шаардлага	8
5.3 Зөвлөмж	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар, Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54 И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn <u>2026.03.13</u> № <u>853</u> танай _____-ны № _____-т	ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ү.ОЮУНЗУЛ ТАНАА
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээ, зорилтот түвшний гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг	
<p>Байгууллагын захирлын 2025 оны А/04 тушаалаар үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоосон бөгөөд тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 1,556.6 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 338.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 922.2 сая төгрөгийн барилга, сантехник, цахилгааны их засварын ажлыг хөрөнгөд бүртгэх тухай Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/422 тоот тушаал гарсан байна.</p>	
Бусад асуудал	
<p>Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 97.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.</p>	
<small>C:\Users\aranga\Documents\2025\2025 оны санхүүгийн тайлан\2025.docx</small> 1426050013	

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	1,074,379,552.53	856,880,108.84
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	613,396,879.87	340,444,361.91
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	12,497,244.41	1,376,072.88
1.1.4	Бусад авлага	1,161,000.00	1,406,800.00
1.1.6	Бараа материал	447,324,428.25	513,652,874.05
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,074,379,552.53	856,880,108.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	3,618,701,259.14	3,588,313,897.76
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,250,896,592.61	2,222,949,231.25
1.2.2	Биет бус хөрөнгө	1,367,804,666.53	1,365,364,666.51
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,618,701,259.14	3,588,313,897.76
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,693,080,811.67	4,445,194,006.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	57,578,765.02	31,996,646.29
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	49,561,820.60	26,652,016.67
2.1.1.3	Татварын өр	33,010,709.50	23,935,016.67
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	16,551,111.10	2,717,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	49,561,820.60	26,652,016.67
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	8,016,944.42	5,344,629.62
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,016,944.42	5,344,629.62
2.2	Өр төлбөрийн нийт дүн	57,578,765.02	31,996,646.29
2.3	Эздийн өмч	4,635,501,746.65	4,413,197,360.31
2.3.1	Өмч: - төрийн	106,219,259.00	106,219,259.00
2.3.8	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	1,347,328,000.00	1,347,328,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,132,645,875.51	2,132,645,875.51
2.3.9	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	1,049,308,612.14	827,004,225.80
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,635,501,746.65	4,413,197,360.31
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,693,080,511.67	4,445,194,006.60

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,730,610,387.05	1,556,596,742.88
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,124,634,715.89	930,537,061.12
3	Нийт ашиг/алдагдал/	605,975,671.16	626,059,681.76
8	Түрээсийн орлого	35,800,000.00	64,513,305.77
9	Хүүний орлого	62,490,116.13	25,084,467.97
10	Бусад орлого	242,836,128.54	248,609,941.40
11	Борлуулалт, маркетингийн зардал	283,305,705.20	452,840,348.04
12	Ерөнхий ба удирдлагын зардал	454,868,313.59	722,890,308.16
14	Бусад зардал	21,419,704.86	176,185.00
16	Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз (гарз)		34,696,837.04
19	Бусад ашиг алдагдал		(99,451,405.00)
20	Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал/	187,508,192.18	(146,884,876.34)
21	Орлогын албан татварын зардал	19,910,225.51	-
22	Татварын дараах ашиг алдагдал	167,597,966.67	(146,884,876.34)
24	Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/	167,597,966.67	(146,884,876.34)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	1,030,506,600.39	4,616,699,734.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(5,346,404.00)	(5,346,404.00)
3	Залруулсан үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	1,025,160,196.39	4,611,353,330.90
4	Зарласан ноогдол ашиг				(143,450,460.00)	(143,450,460.00)
5	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				167,598,875.76	167,598,875.76
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	1,049,308,612.15	4,635,501,746.66
7	Залруулсан үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	1,049,308,612.15	4,635,501,746.66
8	Өмчид гарсан өөрчлөлт			-	(75,419,510.00)	(75,419,510.00)
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(146,884,876.34)	(146,884,876.34)
10	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	827,004,225.81	4,413,197,360.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,301,014,754.04</u>	<u>2,159,986,352.68</u>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,295,408,246.64	2,146,112,909.42
1.1.4	Бусад мөнгөн орлого	5,606,507.40	13,873,443.26
1.2	Мөнгөн зарлагын дүн	<u>2,327,292,528.16</u>	<u>2,332,083,560.64</u>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	369,753,065.00	895,886,155.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	161,483,477.12	252,524,303.50
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,206,096,268.43	399,159,074.45
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	233,092,667.00	421,408,434.05
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,360,506.46	1,100,237.10
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	6,249,011.61	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	214,166,105.41	271,411,217.72
1.2.9	Бусад мөнгөн зарлага	135,091,427.13	90,594,138.82
1.3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(26,277,774.12)</u>	<u>(172,097,207.96)</u>
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	62,490,116.13	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	62,490,116.13	-
2.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	126,182,899.93	25,435,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	126,182,899.93	25,435,500.00
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(63,692,783.80)</u>	<u>(25,435,500.00)</u>
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	143,450,460.00	75,419,510.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	143,450,460.00	75,419,510.00
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(143,450,460.00)</u>	<u>(75,419,510.00)</u>
4	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>(233,420,717.92)</u>	<u>(272,952,217.96)</u>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	846,817,597.79	613,396,879.87
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	613,396,879.87	340,444,661.91

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төлөв/ 2025 гүйц	Хувь
	Хуримын тоо	1,038	1,100	736	(302.00)	70.9	(364.00)	66.9
1	Хуримын үйлчилгээний орлого	1,730,610.4	2,383,700.0	1,556,596.7	(174,013.7)	89.9	(827,103.3)	65.3
	Түрээсийн орлого	35,800.0	59,000.0	64,513.3	28,713.3	180.2	5,513.3	109.3
	Хүүний орлого	62,490.1	20,000.0	25,084.5	(37,405.6)	40.1	5,084.5	125.4
	Бусад орлого	242,836.1	263,140.0	248,609.9	5,773.8	102.4	(14,530.1)	94.5
2	Нийт орлого	2,071,736.6	2,725,840.0	1,894,804.4	(176,932.2)	91.5	(831,035.6)	69.5
3	Нийт зардал	1,884,228.4	2,705,786.1	2,041,689.3	157,460.9	108.4	(664,096.8)	75.5
	Үүнээс: Удирдлагын зардал	454,868.3		722,890.3	268,022.0	158.9	722,890.3	-
4	Татварын өмнөх ашиг	187,508.2	20,053.9	(146,884.9)	(334,393.1)	(78.3)	(166,938.8)	(732.5)
5	Цэвэр ашиг /алдагдал/	167,598.0	18,048.5	(146,884.9)	(314,482.9)	(87.6)	(164,933.4)	(813.8)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	424,437.6	235,103.6	453,441.5	29,003.9	106.8	218,337.9	-
	а/ Орлогын татварт	13,891.3			(13,891.3)	-	-	
	б/ НӨАТ	110,701.4		140,994.8	30,293.4	127.4	140,994.8	
	в/ НДШ	84,335.6	142,184.1	133,144.0	48,808.4	157.9	(9,040.1)	93.6
	г/ Хүн амын орлогын татвар	55,534.0		87,359.2	31,825.2	157.3	87,359.2	
д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	16,524.8	17,500.0	16,524.0	(0.8)	100.0	(976.0)	94.4	
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	143,450.5	75,419.5	75,419.5	(68,031.0)	52.6	0.0	
8	Нийт ажиллагсдын тоо	29.0	37.0	33.0	4.0	113.8	(4.0)	89.2
9	Нийт цалингийн сан	574,902.6	861,722.0	635,048.0	60,145.4	110.5	(226,674.0)	73.7
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	1,200.0	1,590.0	1,484.0	284.0	123.7	(106.0)	93.3
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.9	1.0	0.7	(0.2)	76.9	(0.3)	70.0
12	Хөрөнгө оруулалт	126,182.9	1,600,000.0	1,519,555.5	1,393,372.6	1,204.2	(80,444.5)	95.0
13	Нийт авлага	11,220.0	-	1,406.8	(9,813.2)	12.5	1,406.8	
	Үүнээс: Найдваргүй		-	-	-	-	-	
14	Нийт өглөг	57,578.8	-	32,024.3	(25,554.5)	55.6	32,024.3	
	Богино хугацаат өр төлбөр	49,561.8	-	26,679.7	(22,882.1)	53.8	26,679.7	
	Урт хугацаат өр төлбөр	8,016.9	-	5,344.6	(2,672.3)	66.7	5,344.6	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,376.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,376.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн 1,376.1 мянган төгрөгийн авлагатай гарсныг Санхүү байдлын тайланд авлагаар тусгаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг дансанд сөрөг утгатай илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1, Санхүүгийн тайлангийн Толилуулга стандартын заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасантай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 9,812.1 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 684.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 9,128.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Кассаас худалдан авсан 755.0 мянган төгрөгийн бараа материалыг бичиг хэргийн материалын дансанд орлогодоогүй шууд зарлагадаж зардлын дансанд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-т “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.5-д “*бүх орлого*” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын орлогыг тухай бүрд нь тооцооны дансаар дамжуулж бүртгэх, зарцуулалтын тайланд тусгах

Илрүүлэлт 2: Худалдан авсан 684.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансанд орлогодоогүй шууд зарлагадаж зардлын дансанд бүртгэсэн, шатахуун зарцуулалтын замын тооцооны хуудас байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-т “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.5-д “*бүх орлого*” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны орлогыг тухай бүрд нь тооцооны дансаар дамжуулж бүртгэх, зарцуулалтын тайланд тусгах

2. Өглөг данстай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт 3: Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өр төлбөрийн эхний үлдэлдэл, Е-тах татварын систем дэх үлдэгдэл хооронд зөрүүтэй байгаа нь өмнөх онуудын татварын систем дэх үлдэгдэл зөрүүтэй байсантай холбоотой ба 8,373.1 мянган төгрөгийн зөрүүг тулган баталгаажуулалт хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д *“Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”* заалтуудтай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын байгууллагатай тооцоо нийлж өмнөх онд үүссэн зөрүүг арилгах арга хэмжээ авах, өр төлбөрийг бүрэн барагдуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	НДШ-ийн тайлангаар гарсан авлагыг Санхүү байдлын тайланд авлагаар тусгаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг дансанд сөрөг утгатай илэрхийлсэн	1	1,376.1			1	1,376.1	1	1,376.1				
	Дүн	1	1,376.1			1	1,376.1	1	1,376.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Кассаас худалдан авсан 755.0 мянган төгрөгийн бараа материалыг бичиг хэргийн материалын дансанд орлогодоогүй шууд зарлагдаж зардлын дансанд бүртгэсэн	1	755.0					1	755.0				
2	Худалдан авсан 684.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансанд орлогодоогүй шууд зарлагдаж зардлын дансанд бүртгэсэн, шатахуун зарцуулалтын замын тооцооны хуудас байхгүй байна.	1	684.0					1	684.0				
3	Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өр төлбөрийн эхний үлдэлдэл, E-tax татварын систем дэх үлдэгдэл хоорондоо зөрүүтэй байгаа нь өмнөх онуудын татварын систем дэх үлдэгдэл зөрүүтэй байсантай холбоотой ба 8,373.1 мянган төгрөгийн зөрүүг тулган баталгаажуулалт хийгдээгүй байна.	1	8,373.1					1	8,373.1				
	Дүн	3	9,812.1					3	9,812.1				